

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Хайдаг ингэ

/өгүүллэгийнхэсгээс/

...Тэгтэл үрдээ харууссаных нь ч уу, эмгэний хөөслөх дуу аялгад уярч хайлсных ч уу хоёр нүдний нь нулимс хэлхээ нь тасарсан сувд шиг том томоор бөмбөрч эхлэх агаад үүнтэй зэрэгцэн эмгэний нулимс ч хоёр хацрыг нь даган зам татуулан урсана. Ээ дээ, ийм үед нь ч ёстой нүд халтираад харах янзгүй дээ. Энэ хорвоогийн эх амьтад гэдэг ялгаагүй ийм байдаг бололтой.

Нэг хавар цөхрөхдөө түүнийг хүнтэй адил санаад нэгэнт босч ирэхээсээ өнгөрсөн ботгыг нүднээс нь далд хийж мартагнуулах санаагаар хээр аваачаад булчихсан чинь яасан гэж санана. **Ийш тийш нь эрж харайлгаж, буйлж гунганан хүнээр юм бол орилж бахирч гүйгээд, идэж уух, унтаж амрахаа мартчихсан, тэгээд нөгөө үхсэн ботгоныхоо газар дээр очоод нулимс бөмбөрүүлэн гунганаж нэхээд байх нь тэр. Холдож нүүгээд ч ялгаагүй. Хэчнээн хол газар туугаад очлоо ч буцаж гүйж тэр газар дээрээ ирээд л уйлаад байна.** Чингисийн онгоныг нууцлах гэж газар дээр нь ботго алж ингээр туршилт хийсэн тухай яриа байдаг нь ч үүнтэй холбоотой биз./М.Жавган/

1. Үхсэн ботгыг хаана булсан бэ?
 А.Хээр газар В.Чингисийн онгоныг нууцлах газар С.Нүүж очсон газраа
 D.Эмгэнийхээс холгүй E.Нэгэн довцог толгойн ард
2. Эмгэн ингийг яагаад хөөсөлдөгвэ?
 А.Эмгэн үхсэн ботгыг нь хараад ихэд харууссан учраас
 В.Ингийг өрөвдөн чинэсэн дэлэнг нь хөнгөлөхийн тулд
 С.Ингэний зовлонг нимгэлж аргадахын тулд
 D.Нүд халтираад харж чадахгүй байсан учраас
 E.Эмгэн үхсэн ботгыг нь мартагнуулахын тулд
3. Таамаглах баймж утга илэрсэн өгүүлбэрийг голоорой.
 А.Ээ дээ ийм үед нь ч ёстой нүд халтираад харах янзгүй дээ
 В....мартагнуулах санаагаар хээр аваачаад булчихсан чинь яасан гэж санана
 С.Энэ хорвоогийн эх амьтад гэдэг ялгаагүй ийм байдаг бололтой
 D. ...нулимс бөмбөрүүлэн гунганаж нэхээд байх нь тэр
 E. ...буцаж гүйж тэр газар дээрээ ирээд л уйлаад байна
4. "...том томоор бөмбөрч эхлэх агаад үүнтэй зэрэгцэн эмгэний нулимс ч хоёр хацрыг нь даган зам татуулан урсана" гэсэн дүрслэлд тохирсон хэлцийг сонгоноуу.
 А.Үхтэл үр харам
 В. Үргүй хүн үхэхийн цагт гутамшиг, үгээгүй хүн намрын цагт гутамшиг
 С.Үртэй хүн шуугина, үндэстэй мод найгана
 D.Тэмээ хариулсан хүн буурныхаа занг андахгүй
 E.Үргүй хүний нүд нойтон, үртэй хүний өвөр нойтон
5. Эхийн өнгө аясыг зөв тодорхойлсныг олоорой.
 А. Ингэ, эмгэн хоёрыг нүд халтираад харахын аргагүй байгааг голлон илэрхийлж буйтул харуусал өнгө аястай
 В.Ингийг хэчнээн хол туусан ч буцаж ирээд эрж харайлган буйлж, гутарч буйг голлон илэрхийлсэн тулгуниглуун өнгө аястай
 С.Чингисийн онгоныг нууцлах гэж газар дээр нь ботго алж ингээр туршилт хийсэн яриаг гол болгосон тултааварласан өнгө аястай
 D.Хүнээр юм бол орилж бахирч гүйгээд, идэж уух, унтаж амрахаа мартчихсанг илэрхийлсэн тулшанал өнгө аястай
 E. Үр төлөө нэхэн туйлдсан ингэ, түүнийг аргадаж аядсан эмгэн хоёрын байдал нь цөхрөл

- өнгө аястай
6. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг олоорой.
А.Ингэний дүр байдлын олон шинжийг нь зурагласан тул тоочимж
В.Хэрэг явдлын бодомжийн харьцаанаас шинэ дүгнэлт гаргасан тул эргэцүүлэмж
С.Үйл явдлын шалтгаант холбоог зэрэгцүүлэн үзүүлсэн тул хүүрнэмж, тоочимж хосолсон хэв маяг
D.Эмгэнд тохиолдсон явдлыг цагийн дарааллын дагуу үзүүлсэн тул хүүрнэмж
E. Ингэний үхсэн ботгыг хээр аваачиж булсны учрыг олон талаар задлан тайлбарласан тул тайлбарламж
7. Дараах өгүүлбэрүүдээс эхийн санаанд холбогдолгүй хэсгийг олоорой.
А.Энэ хорвоогийн эх амьтад гэдэг ялгаагүй ийм байдаг бололтой
В.Үрдээ харууссаных нь ч уу, эмгэний хөөслөх дуу аялгад уярч хайлсных ч уу
С.Холдож нүүгээд ч ялгаагүй тэр газартаа хүрээд л очно
D.Чингисийн онгоныг нууцлах гэж газар дээр нь ботго алж ингээр туршилт хийсэн
E.Эмгэний нулимс ч хоёр хацрыг нь даган зам татуулан урсана
8. “Ээ дээ, ийм үед нь ч ёстой **нүд халтираад харах янзгүй дээ**” гэсэн өгүүлбэрийн онцолсон хэсгийн утгад тохирохыг нь олоорой.
А.зүрх дэлсмээр В.зүрх үхмээр С.зүрх шимширмээр
D.зүрх алдмаар E.зүрх гаргамаар
9. “Хоёр нүдний нь нулимс хэлхээ нь тасарсан сувд шиг том томоор бөмбөрч эхлэх **агаад** үүнтэй зэрэгцэн эмгэний нулимс ч хоёр хацрыг нь даган зам татуулан урсана” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг солин найруулбал аль нь оновчтой байх вэ?
А. боловч В. бөгөөд С. буюу D. атал E. байтугай
10. “Ингэ ботгыг нь булсан газар дээрээ ирээд л уйлаад байна” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг сонгоорой.
А. адилтгал В. зүйрлэл С. хүншүүлэл D. багасгал E. хэтрүүлэл
11. “Нөгөө үхсэн ботгоныхоо газар дээр очиж гэнэ” гэсэн өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
А. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
В. Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
С. Угсарсан нийлмэл өгүүлбэр
D. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр
E. Холимог нийлмэл өгүүлбэр
12. “Ботгоо нэхэж гэнэ, хөөрхий хөөрхий” гэсэн өгүүлбэрт тохирох загварыг олоорой.
А. Энгийн өгүүлбэр + мэдрэх өгүүлбэр
В. Энгийн өгүүлбэр + зөвших өгүүлбэр
С. Энгийн өгүүлбэр + хандах өгүүлбэр
D. Энгийн өгүүлбэр + илэрхийлэх өгүүлбэр
E. Энгийн өгүүлбэр + энгийн өгүүлбэр
13. Цөм бус бүтэцтэй өгүүлбэрийг олоорой.
А. Нулимс бөмбөрнө
В. Ботгыг булна
С. Хээр аваачина
D. Онгоныг нууцална
E. Туршилт хийнэ
14. Эхийн өгүүлбэрүүдээс тонгоргон хувиргасныг олоорой.
А. Нүдний нь нулимс сул асгасан сувд шиг том томоор бөмбөрнө.
В. Эмгэний нулимс ч хоёр хацрыг нь даган урсана
С. Холдож нүүгээд ч ялгаагүй байлаа

- D.Эмгэний хөөслөх дуу аялгад уярч хайлсных ч уу, үрдээ харууссаных нь ч уу
E.Ийм үед нь ч ёстой нүд халтираад харах янзгүй дээ
15. Найруулгын зэргээрээ ялгарах өгүүлбэрийг сонгоорой.
A.Наран ургахын хэрд ингэ эмгэнийг зорин айсуй
B.Эмгэний нулимс ч хоёр хацрыг нь даган урсана
C.Энэ хорвоогийн эх амьтад гэдэг ялгаагүй
D.Хээр аваачаад булчихсан чинь яасан гэж санана
E. Ээ дээ, хүний үзэж туулах амьдралд ховорхон тохиолдоосой
16. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонгоно уу.
том томоор, энэ хорвоо, газар дээр,
A.дуу аялга B.нэг хаварC.нүд халтирахD.ууж идэхE. сувд шиг
17. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай үгийг олоорой.
A. хүнB.зам C.хацар D.нүд E.эмгэн
18. “Чингисийн **онгоныг** нууцлах гэж газар дээр нь ботго алж ингээр туршилт хийсэн тухай яриа байдаг нь ч үүнтэй холбоотой биз” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
A.Эрхэмлэн тахисан хүүр булш
B.Засаглах эрхийн баталгаа болгосон тамга тэмдэг
C.Эзэн хааны эдэлж байсан хувцас, эдлэлийн зүйлс
D.Чингис хааны төрийн бодлогын алтан гэрээ бүхий судар
E.Хааны асар их үнэт эрдэнэс
19. “...Нэг хавар цөхрөхдөө **түүнийг** хүнтэй адил санаад...” гэсэн өгүүлбэрийн онцолсон үг юуг төлөөлснийг олоорой.
A. ингийг B.ботгыг C.Чингисийн онгоныг D.сувдыг E. эх амьтдыг
20. Төрөл биш утгатай үгийг олоорой.
A. нууц B.нууцал- C.нуур D.нуувч E.нууцгай
21. Эхээс сонгосон үгсээс үгийн бүтцээр зөв задалсныг нь олоорой.
A. гун+гана+0+0+ж B.зэрэг+ц+0+н C. тат+0+уул+н
D.март+гна+0+уул+хE.хөө+с+л+0+х
22. “Нөгөө үхсэн ботгоныхоо газар дээр очоод нулимс бөмбөрүүлнэ” гэсэн өгүүлбэрийн “нулимс” гэсэн үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
A. байц B.өгүүлэгдэхүүн C.үйлийн тодотгол
D.шууд тусагдахуун E.шууд бус тусагдахуун
23. Зөв бүлэглэсэн/угсруулах холбоо/ хэсгийг сонгоорой.
A.хацрыг нь дагах, хэлхээ нь тасрах, эмгэний нулимс
B. хээр аваачих, туршилт хийх, ингэ хөөслөх
C.ууж идэх, хол газар, эх амьтад
D.бөмбөрч эхлэх, том томоор, үрдээ харуусах
E.энэ хорвоо, сувд шиг том, эх амьтад
24. “Хорвоогийн эх амьтад гэдэг ялгаагүй ийм байдаг бололтой” гэсэн өгүүлбэр дэх харьяалахын тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?
A.Бүхэл хэсгийн B.Орны C.Эзэмшлийн
D.Юмны тоо хэмжээний E.Цаг хугацааны
25. “Мал ижил буюу төлөө өхөөрдөн дотнолж дуугарах” гэсэн тайлбарт тохирохыг нь олоорой.
A. гунганаB.буйлахC.бахирах D.хөөслөх E.орилох

34. “-Гомбод ташуур ер тэсдэггүй байсан. Хятадын сайн хулсан ташуур ч олон жил эдлүүлдэг эд дээ. Тэгэхэд Гомбо, хятад хулсан ташуурыг хагас жил хүргэхгүй бяц цохидог байсан. Тийм өөдгүй хүн байсан юм” –ямар зохиолын дүрслэлт хэсэг вэ?
 А. “Хоёр цагаан юм” /Ц.Д/
 В. “Өлзийтийн хээр” /Ц.Д/
 С. “Эмээлтэй морины эзэн ирлээ” /Л.Ц/
 Д. “Шөнийн талд адуу янцгаана” /Д.Ням./
 Е. “Хөдөө талын үзэсгэлэн” /Д.Н/

35. Б.Лхагвасүрэн “Боржгины бор тал” найраглалд хүний өтөл нас, хөгшрөхийг илэрхийлсэн хэсгийг олоорой.
 А.Салхи хөлөглөсөн өд нь чам дээр эргэж буудаг...
 В.Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог...
 С.Тэнгэр тийчиж, чулуу ханарааж төрөхөд тал минь чи торго шиг зөөлөн байсан...
 Д.Нуур тойрмын ширхэг чулуу хүртэл намайг хүн болгосон...
 Е.Багадаа хөхсөн эхийн сүү гадагшлахын цагт...

36. Жангарын туужид:
 “Түвшин Ширхэгийн ач гэнэ
 Бөх Мөнгөн Шигшрэгийн ууган хөвгүүн гэнэ
 Шилтэй зандан Гэрэл хатны
 Эрхэн хорин хоёр настайд нь гарсан...” нь хэн бэ?
 А. Догшин хар Санал В.Хүнд гарт Савар С.Арслангийн Араг Улаан-хонгор
 Д.Баян Хүнхээн Алтан Цээж Е.Орчлонгийн сайхан Миньяан

37. Монгол бичгийн эхийг уншаад зөв хөрвүүлснийг олоорой.
 А. Тайжийн тэмээд тал руугаа тархана
 Тавнангийн хөвүүн нэг нэгээр нь тогтооно
 В. Тайжийн тэмээд тал руу тархана
 Тавнангийн хөвүүн нэг нэгээр нь тогтооно
 С. Тайжийн тэмээд тал руугаа тархана
 Тавнангийн хөвүүд нэг нэгээр тогтооно
 Д. Тайжийн тэмээд тал руугаа тархана
 Тавнангийн хөвүүн нэг нэгээр нь тогтооно
 Е. Тайжийн тэмээдийг тал руу тархаана
 Тавнангийн хөвүүн нэг нэгээр нь тогтооно



38. “тэнгэр” гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэн хэсгийг олоорой.
 А. B. C. D. E.

39. Тийн ялгалын нөхцөлийг зөв дагуулсан хэсгийг олоорой.
 А. B. C. D. E.

40. Холбох эгшгийн дүрмээр бичигдээгүй үгийг олоорой.
 А. B. C. D. E.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1.Хэлцийг утгатай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--------------------------------|------------------|
| a. нохойн дуу ойртох | 1. тал засах |
| b. мөрийг нь алгадах | 2. онгирох |
| c. оготнын нүхэнд багтах | 3. дуусах дөхөх |
| d. сүүлээ сэврээн дээрээ тавих | 4. хөсөрдүүлэх |
| e. уландаа гишгэх | 5. овжин зальтай |

2.2.Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|------------------------|
| a.Унасан хүүхэд нь балчирдаад
Барьсан ташуур нь богинодоод... | 1. Бэлгэ дэмбэрлийн үг |
| b. Жалгын жаврыг хааж хэвтдэг
Жартгай дайсныг айлгаж хөөдөг... | 2. Зүйр цэцэн үг |
| c. Зайгаар салхи ордог
Заавраар ухаан ордог | 3. Ерөөл |
| d.Номчилж боосны нь үзвэл
Номин эрдэнийн шинжтэй... | 4. Магтаал |
| e. Мөнх насалж
Мөнгөн дөрөө дөрөөлөөрэй | 5. Цол |

2.3. Зурагт зааснаар нэртэй нь зөв харгалзуулаарай.

- a.цамхраа
- b.хөшигний хоолой
- c.унины углуурга
- d.чагтага
- e.хөшиг



2.4.Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3	4
a	Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр бичигдсэн үг	хураана	бүртгэгдэв	ганзага	эмхэтгэл

b	Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг өмнө бичнэ гэсэн дүрмийг зөрчиж бичих үг	тус+л	холтос+л	товч+л	хагас+л
c	Зөөлний тэмдэг “и” болохгүй үг	барь+я	барь+мал	барь+г	барь+лга
d	-цгаа ⁴ залгаврыг залгахад эгшиг жийрэглэх үг	өгүүл	тооц	тарь	дуугар
e	Эр үгийн “ы”-г бичих үг	харз	буурцаг	уринш	тахь